



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/258

Булган сум

“Иргэдийн спортын наадам”-ыг зохион байгуулах
ажлын хэсгийг томилж, зохион байгуулалтын
зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор “Иргэдийн спортын наадам”-ыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Пүрэв-Очир (Аймгийн Засаг дарга)
Гишүүд:	М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга) Т.Хонгорзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга) Ё.Хулан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн) Ц.Цолмонбаатар (Боловсролын газрын дарга) Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга) Д.Баасанжав (Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын соёл урлагийн хэлтсийн дарга) П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга) Н.Пүрэвсайхан (Политехникийн коллежийн захирал) Л.Ганболд (Биеийн тамир, спортын газрын спортын хэлтсийн дарга) С.Наранбаатар (Шатрын холбооны тэргүүн) Д.Төрбат (Ширээний теннисний холбооны тэргүүн) Б.Мөнх-Эрдэнэ (Сурын холбооны тэргүүн) П.Содномдорж (Шагайн холбооны тэргүүн)
Нарийн бичгийн дарга:	Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)

2. “Иргэдийн спортын наадам” арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулан ажиллахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

6325010354

3.Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг хавсралтаар баталсугай.


4.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

04 дүгээр сарын 16-ны/ний өдрийн А/258 дүгээр захирамжийн хавсралт



“Иргэдийн спортын наадам”-ын зохион байгуулалтын зардлын төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
1.	1-р байр	1	3,000,000	3,000,000
2.	2-р байр	1	2,000,000	2,000,000
3.	3-р байр	1	1,000,000	1,000,000
Нийт			6,000,000	